



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 21 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 21 дүгээр хуралдааныг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 21 дүгээр хуралдаанаар /2025-10-10/ ХХЗХ-ны Радио давтамжийн хяналт баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх хүрээнд оффисын шинэ барилга барих зураг төслийн загварын тухай (Хоёр дахь хэлэлцүүлэг: Хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдааны үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх); “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг зохион байгуулах тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 11 (Тогтоол №216-226, 2025-10-10) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдаанд /2025-09-30/ ажлын хэсэг, зураг төслийн ажлыг гүйцэтгэгч нар хамтран “ХХЗХ-ны Радио давтамжийн хяналт баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх хүрээнд оффисын шинэ барилга барих зураг төслийн загварын тухай” танилцуулга, мэдээллийг сонсоод, боловсруулсан барилгын зураг загварыг эцэслэхээс өмнө урьдчилсан ТЭЗҮ, холбогдох нэмэлт шаардлагатай зардал, төсөв тооцоо судалгааг боломжийн хэмжээнд (тухайлбал, барилга барих, ашиглалтын үед шаардлагатай дэд бүтэц буюу цэвэр ус, эрчим хүч цахилгаан, дулаан хангамж, шилэн болон уламжлалт барилгын ашиглалтын өртөг, зардлын харьцуулалт, эдийн засгийн үр ашиг г.м)-г дахин судалж, нягтлан боловсруулах талаар гарсан санал зөвлөмж, өгсөн удирдамж чиглэлийг тусган 2025 оны 10 дугаар сард багтаан Хорооны хуралдаанаар Ажлын хэсэг /Н.Эрдэнэбулган/-ээс барилгын зураг төсвийн гүйцэтгэгч байгууллагатай хамтран хэлэлцүүлэхийг хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгосон юм. Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдаанаар эдгээр удирдамж, чиглэл болон үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор ажлын хэсэг, гүйцэтгэгч байгууллагаас хамтран боловсруулсан “ХХЗХ-ны Радио давтамжийн хяналт баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх хүрээнд оффисын шинэ барилга барих зураг төслийн загварын тухай” нэмэлт судалгаа, танилцуулга, харьцуулалт болон барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалт, цаашид шаардлагатай хөрөнгө оруулалт, ашиглалтын зардлын тооцоо зэргийг авч хэлэлцэв. Ажлын хэсэг /Ч.Эрдэнэбулган/, шалгарсан зураг төсөв ажлын гүйцэтгэгч байгууллагаас энэ барилгын нарийвчилсан судалгаа, хэрэгжүүлэх дэд бүтэц, хөрөнгө оруулалт, зардал (ТЭЗҮ), 2026 онд, дунд хугацаанд шаардлагатай хөрөнгө оруулалт, барилгын ажлыг гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг “ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсөв төлөвлөгөө”-ний төсөлд тусган боловсруулж,

2025 оны 12 дугаар сард багтаан Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /Ч.Эрдэнэбулган/, ЗУХАГ /З.Эрдэнэчулуун/, Санхүүгийн хэлтэс /Н.Халиунаа/-т тус тус даалгахаар тогтов.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”, тус тогтоолд нэмэлт оруулсан 2023 оны 88 дугаар тогтоолыг баримтлан Улаанбаатар хотод радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулах, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг тус тус боловсруулсан байна. Тус хорооны 2025 оны ээлжит 21 дүгээр хуралдаанаар РДЗХГ-аас “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг зохион байгуулах тухай танилцуулга, нэр бүхий хуулийн этгээд нараас ирүүлсэн хүсэлт санал, тогтоолын төсөл, тогтоолын хавсралт болох “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ын баримт бичгийн төслийг тус тус хэлэлцэв. Энэхүү хуралдаанаас Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 216 тоот “Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зарлаж, “Сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээний ажлын хэсэг байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 21 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 10 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 10 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 217 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Юни цэц ХХК: “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх”) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 218 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Прогресстранс ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс –БНХАУ/) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, , 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 219 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (МЭТИС констракшн ХХК; Инфра мета ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 220 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (ЖСММ БГБХ нөхөрлөл: Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” 13400060 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 221 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Аршгүүр ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс–Польш Улс/, 43200185 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 222 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн (Монгол Улсын их сургууль; Мобинет ХХК) 2 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 223 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн (Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ: 1900-1234) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2, 14.12.3 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 224 тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Аз монобе жи пи эм ХХК: Монгол улсын нутаг дэвсгэрт Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх, 43200220 тоот тусгай зөвшөөрлийг; Эргэлдэй ХХК: Монгол улсын нутаг дэвсгэрт Улс хоорондын шуудангийн

үйлчилгээ эрхлэх, 43200197 тоот тусгай зөвшөөрлийг) 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2, 14.12.3 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 225 тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 18 хуулийн этгээдийн 18 тусгай зөвшөөрлийг (тогтоолын хавсралтын 1-т заасан “Интернэтийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл, 2-оос 18-д заасан хуулийн этгээдүүдийн “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх”) 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2 дахь заалт, 14.12.3 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 226 тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 9 хуулийн этгээдийн 9 тусгай зөвшөөрлийг (тогтоолын хавсралтын 1-т заасан хуулийн этгээдийн “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл, 2-т заасан хуулийн этгээдийн “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл, 3-аас 6-д заасан хуулийн этгээдүүдийн “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл, 7-оос 9-т заасан хуулийн этгээдүүдийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг) 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлж тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-10-17